


ОЙН НӨӨЦ, ОЙ ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2020 ОНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Төслийн нэр: “Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн дагалт баялгийн судалгаа”

Захиалагч: Нийслэлийн Байгаль Орчны Газар, “Хотын нөөц баялгийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх замаар Тогтвортой Хөгжил-2030 хөтөлбөрийг нутагшуулах” төсөл

Санхүүжүүлэгч: НҮБ-ийн Ази Номхон Далайн бүс нутгийн Эдийн засаг-нийгмийн комисс

Төслийн зорилго: Улаанбаатар хотын ногоон бүсийн хушин ойн төлөв байдал, ойн дагалт баялгийн судалгаа явуулж, хамгаалах, зүй зохистой ашиглах зөвлөмж, гарын авлага боловсруулах болон байгаль хамгаалагч нарыг чадавхижуулахад чиглэсэн.



Зураг 1. Судалгаа явуулсан газар нутаг

Судалгааны арга зүй. Хээрийн судалгаанд дээж талбайн аргыг ашигласан бөгөөд моддын хэмжилт тооллогод Н.Л.Анучин, ойн моддын төлөв байдлын үнэлгээнд Д.Цэндсүрэн (2009), үрлэлтийн зэргийг тодорхойлоход А.А.Корчагин, үрийн чанарын үзүүлэлтүүдэд Олон Улсын Үр Шинжилгээний Журам (International Rule on Seed Testing), шавжийн судалгаанд Мозолевский нарын арга зүйг үндэслэл болгов. Өгөгдөл боловсруулахад JMP-5.1, SPSS, R статистикийн багц програмуудыг ашигласан.

Судалгааны үр дүн.

Ойн төлөв байдлын үнэлгээнээс үзэхэд, судалгаанд хамрагдсан газруудын хувьд бүх мод нь эрүүл биш, 60 гаруй хувь нь өсөлт саарч буй, 30 гаруй хувь нь өсөлт зогсож, доройтож буй ангилалд хамаарагдаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хушин ойн моддын төлөв байдлын үнэлгээ

Дээж талбай	Ойн моддын төлөв байдлын түвшин	Рекреацийн талхлалын зэрэг
Дэндий	Өсөлт зогсож доройтож буй	III –Ойн орчин дунд зэрэг өөрчлөгдсөн
Санзай	Өсөлт саарч буй	III –Ойн орчин дунд зэрэг өөрчлөгдсөн
Жигжид	Өсөлт саарч буй	II –Ойн орчин өөрчлөгдөж эхэлж буй
Нүхт	Өсөлт саарч буй	IV –Ойн орчин талхлагдаж буй
Түргэн	Өсөлт зогсож доройтож буй	IV –Ойн орчин талхлагдаж буй
Улиастай	Өсөлт саарч буй	II –Ойн орчин өөрчлөгдөж эхэлж буй
Хандгайт	Өсөлт саарч буй	II –Ойн орчин өөрчлөгдөж эхэлж буй
Тэрэлж	Өсөлт зогсож доройтож буй	III –Ойн орчин дунд зэрэг өөрчлөгдсөн


Үрийн ургац нэг хүчин зүйлт вариансын анализын шинжилгээгээр статистикийн хувьд ($p=0.0001$) ялгаатай буюу Дэндий, Жигжидийн ойд бага, Санзайн амны ойд дундаж, Нүхт, Улиастай, Түргэний аманд их ургацтай байв. Үрийн амьдрах чадварын үзүүлэлтийг нэг хүчин зүйлт вариансын анализаар шинжлэхэд статистикийн хувьд ялгаатай ($p=0.0001$), Данканы (MRT) олон хувилбарт шалгуураар Нүхт, Түргэн, Улиастайн амны үрийн амьдрах чадварын үзүүлэлт хамгийн сайн буюу А, Дэндийн амны үрийн амьдрах чадвар хамгийн бага буюу С үнэлгээтэй байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хушин ойн үрийн ургацын үнэлгээ, үрийн чанарын үзүүлэлтүүд

Дээж талбай	Үрийн ургацын үнэлгээ, балл	Үрийн гарц, ш	Үрийн амьдрах чадвар, %
Дэндий	2	92	51.3 с
Санзай	3	56	62.6 b
Жигжид	1	74	58.2 bc
Нүхт	4	99	82.6 a
Түргэн	4	90	76.5 a
Улиастай	4+	108	73.8 a

Үрийн амьдрах чадварын ялгаа $F=15.52$ $df=5$ $p=0.0001$

Моддын диаметрийн өсөлтийн шинжилгээний дүнгээс үзэхэд, Жигжид, Улиастайн амнаас бусад газарт моддын өсөлт сүүлийн 20 жилд ерөнхийдөө буурсан хандлагатай байна. Тухайлбал, Дэндий, Нүхт, Түргэний амны моддын диаметрийн өсөлтийн явц нь буурсан үзүүлэлттэй байна (Зураг 2).



Зураг 2. Жигжидийн амны хуш модны диаметрийн өсөлтийн явц



Зураг 3. Сибирийн хүр эрвээхий, хүрэнцэр (*Dendrolimus sibiricus* Tschetv)


Хээрийн судалгаагаар навч шилмүүс, үр боргоцойгоор хооллогч нийт 7 зүйл шавжийн тархалтыг илрүүлэв. Энэхүү 7 зүйл шавжуудаас Сибирийн хүр эрвээхий (*Dendrolimus sibiricus* Tschetv) (Зураг 3), хушны




Зураг 4. Боргоцойн галч эрвээхий, хүрэнцэр (*Dioryctria abietella* F)

боргоцойгоор хооллогч
Боргоцойн галч эрвээхий
(*Dioryctria abietella* F) (Зураг 4)
хушин ойд хөнөөл ихээр
учруулдаг.

Модлог идэштшавжийн судалгаагаар түгээмэл тархалттай овгуудын шавжийн нүхний нягтшилыг тодорхойлоход Нүхтийн аманд хамгийн их, Жигжид, Түргэний амнуудад дундаж үзүүлэлттэй, Дэндийн аманд хамгийн бага байна. Үүнийг статистикийн хувьд шалгаж үзэхэд эдгээр талбайнууд модлог идэшт шавжинд өртсөн байдлаараа мэдэгдэхүйц ялгаа илэрсэнгүй $P=0.14$ (Зураг 5).



Зураг 5. Ялгаатай төлөв байдал ба амьдрах орчин дахь шавжийн нүхний нягтшил



Зураг 6. Нүхний нягтшил модны төрлөөс хамаарсан байдал

Модлог идэшт цохын нүхний тооллогын цуглуулсан дээжинд тулгуурлан вариансын анализаар шинжлэхэд хуш модонд цохын нягтшил хамгийн их, модны төрлүүд хоорондоо шавжийн нүхээрээ ялгаагүй байна ($p=0.26$). Тоологдсон нүхийг овгийн хувьд авч үзвэл холтосч цохын (*Scolytidae*) нүх хамгийн их байхад эвэрт цох болон (*Cerambycidae*) мөлгөр цохын (*Buprestidae*) нүх харьцангуй бага илэрч байна (Зураг 6).

Гэрээт ажлын хүрээнд гарсан үр дүн:

1. Удвал Б. 2020. “Хушны самрыг зүй зохистой түүж бэлтгэх, ашиглах” онлайн ном, УБ, 26 х.
2. Цагаанцоож Н., Батчөдөр Б., Ганбат Д. 2020. “Ногоон бүсийн ойд зонхилон тархсан хөнөөлт шавжийг таних, тэмцэх арга”, УБ, 39 х.
3. “Ойн дагалт баялгаа зохистой ашиглаж үр шимийг нь өнө удаан хүртэцгээе” суртчилгааны самбарыг НБОГ-тай хамтран хийж ногоон бүсэд 3 газар байршуулсан.
4. TV 24-д “Хушин ой, түүний аштглалт, хөнөөлт шавьжийн тархалт” сэдвээр ярилцлага өгсөн
5. “Ногоон бүсийн ойн тогтвортой менежментийн хэрэгжилтийг хангуулах нь” чадавхийг бэхжүүлэх сургалтыг НБОГ-ын мэргэжилтэн, байгаль хамгаалагч зэрэг 60 хүнд 2020 оны 9-р сарын 21-23-ны өдрүүдэд “Ориент плаза” төвийн хурлын танхимд зохион байгуулав.